



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар 20.1.12 дахь хэсгийг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100078

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын
27-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралт



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төрийн бодлого, зорилт, хууль тогтоомж, бүх шатны Хурлын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, дүүрэг орон нутгийг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан байгууллага аж ахуйн нэгж, албан хаагч, иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын хамтарсан шагналаар шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Дүүрэг орон нутгийг хөгжүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх үйлсэд бодит хувь нэмрээ оруулсан Монгол улсын болон гадаадын иргэнийг шагнаж болно.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал нь дараах ангилалтай байна.

2.1.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал-Засаг даргын хамтарсан шагнал:

- а/ “Дүүргийн шилдэг аж ахуйн нэгж байгууллага” цом, өргөмжлөл;
- б/ Чингэлтэй дүүргийн “Хүндэт иргэн ” батламж, зүүсгэл ;

2.1.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:

- а/ “Чандмань одон” үнэмлэх;
- б/ “Хүндэт өргөмжлөл” ;

Гурав. Шагнал олгох болзол, шалгуур

3.1. Энэхүү журмын 2.1.1-д заасан шагналыг шинэ жилийн баярын өдрөөр, 2.1.2-т заасан шагналыг бүх нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тухайн байгууллагын ойгоор олгоно.

3.2 “Шилдэг аж ахуйн нэгж байгууллага”-ын шагналын зорилго нь Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар дүүргийн нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодит, хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж байгууллага, хамт олныг шилдгээр шалгаруулан шагнахад оршино.

3.2.1 Шилдэг аж ахуйн нэгжийг дараах төрлөөр шалгаруулж, шагнана. Үүнд:

- 1. “Шилдэг тохижилттой байгууллага” хамт олон

2. “Шилдэг татвар төлөгч” хамт олон
3. “Шилдэг ажил олгогч” хамт олон
4. “Байгаль орчинд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэгч” хамт олон
5. “Хүүхдэд ээлтэй хүмүүнлэг” хамт олон
6. “Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч” шилдэг байгууллага хамт олон
7. “Шинийг санаачлагч, бүтээлч” хамт олон
8. “Шилдэг Төрийн бус байгууллага” хамт олон
9. “Хуулийг дээдлэгч байгууллага” хамт олон

3.2.2 Шилдэг аж ахуйн нэгж байгууллагаар шалгаруулж шагнахад дор дурдсан нийтлэг болзлыг харгалзан үзнэ.

- Тухайн салбартаа 5-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж, тус салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.
- Ажлын байр бий болгох зорилтын хүрээнд www.Job.mn сайтад бүртгэлтэй байх, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллага, Төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг, дадлагын сургалтыг чанартай зохион байгуулсан байдал
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйл ажиллагаа нь чанар, стандартын шаардлага хангасан, байнгын түнштэй, түүхий эд материалаа дотоодоосоо хангадаг, борлуулалт, чанар хүртээмж нь олон нийтэд таашаагдсан танигдсан байх
- Бүтээгдэхүүний борлуулалтаараа дүүрэг, орон нутагтаа тэргүүлсэн, бүтээгдэхүүн нь байгаль орчинд ээлтэй, хор хөнөөлгүй тухай мэргэжлийн байгууллагаас дүгнэсэн
- Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө болон тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлтэй уялдуулан өөрийн хөрөнгөөр байгууллага орчноо үлгэр жишээ тохижуулсан байх
- Дүүргийн төсвийн бүрдүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулж, төлсөн татварын хэмжээ нь жил дарааллан өссөн үзүүлэлттэй, татварын аливаа зөрчилгүй байх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх энэ чиглэлээр дүүргээс дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа чанд баримтлан, зөрчил гаргаагүй байх, ажлын байр орчин тойрондоо хяналтын камер болон бусад урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авсан байх
- Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр нийгмийн сайн сайхны төлөө дүүрэг орон нутагтаа хүмүүнлэг, оюуны болон бүтээн байгуулалтын чиглэлээр бодит үр дүнтэй ажил зохион байгуулсан байх
- Төрийн бус байгууллагууд үйл ажиллагааныхаа чиглэлээр Төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, гэрээгээр хэрэгжүүлэх ажил үүргийг хангалттай биелүүлж, дүүрэг орон нутагтаа нийгмийн сайн сайхны төлөөх төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн байх

3.3. “Хүндэт иргэн”-ий шагналын зорилго нь дүүрэг орон нутгийнхаа хөгжил, цэцэглэлт, бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт, улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, шинжлэх ухаан, техник технологи зэрэг салбарт хийж бүтээсэн ажил, амжилтаараа дүүрэг

орон нутгийнхаа нэрийг улс, нийслэл, дэлхийн давцанд дуурсгасан онцгой гавьяа байгуулсан дүүргийн иргэнийг шалгаруулж шагнахад оршино.

3.3.1. “Хүндэт иргэн”-ээр шалгаруулж шагнахад дор дурдсан болзлыг харгалзан үзнэ.

- Хариуцсан ажил, туурвисан бүтээл нь хот, улс, олон улсын хэмжээнд үнэлэгдсэн байх
- Дүүрэг орон нутгийнхаа хөгжлийн төлөө өөрийн мэдлэг чадвараа дайчлан бүтээлч, шинэлэг, санал санаачлага дэвшүүлэн хэрэгжүүлж, Төр, нийгмийн эрх ашгийг хамгаалах үйл хэрэгт гар бие оролцдог байх
- Нийгмийн эмзэг бүлгийнхэнийг /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу иргэд/ дэмжих, асран тэтгэх, тэдэнд сэтгэл санааны болон эд материалын туслалцаа үзүүлэх, нийгмийн сайн сайхны төлөөх үйл хэрэгт идэвхтэй оролцдог байх
- Гэр бүл, үр хүүхдүүдээ өв тэгш өсгөн хүмүүжүүлсэн, аж амьдралаараа бусдад үлгэр дууриалал болж орчин тойрондоо үнэлэгдсэн байх
- Иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж, тэднийг бүлэг зохион байгуулалтад оруулан амьдарч буй орчин тойрондоо эрүүл аюулгүй тав тухтай орчин бүрдүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг санаачлан хийсэн байх

Дөрөв. Хамтарсан шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1 Шагналд нэр дэвшигч нь энэхүү журмын 3.2.2, 3.3.1-д заасан болзлыг хангасан байна.

4.2 Шалгаруултад оролцох аж ахуйн нэгж, иргэнийг дараах байдлаар нэр дэвшүүлж болно. Үүнд:

Шилдэг аж ахуйн нэгжид:

- Аж ахуйн нэгж өөрөө нэр дэвшүүлэх
- Дүүргийн орчин суугчдаас нэр дэвшүүлэх
- Олон нийтийн байгууллага нэр дэвшүүлэх
- Дүүргийн болон хорооны Хурал түүний Тэргүүлэгчид, Засаг даргаас нэр дэвшүүлэх

“Хүндэт иргэн”-д:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
- Дүүргийн Засаг дарга
- Хорооны Иргэдийн Нийтийн Хурал түүний Тэргүүлэгчид
- Хорооны Засаг дарга

4.3 Энэ журмын 3.2.2-д заасан болзлыг хангаж шагнагдсан Аж ахуйн нэгжийг өмнө шагнагдсан шагналаас хойш ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс ахисан нөхцөлд энэхүү журмын 3.2.1-д заасан “Шилдэг аж ахуйн нэгжийн шагнал”-ын өөр төрөлд нэр дэвшүүлж болно.

4.4 “Шилдэг аж ахуйн нэгж байгууллага хамт олон” шагналд нэр дэвшигч байгууллага нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

4.4.1 Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг

4.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр нийгмийн халамжийн хэлтэс, Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтсийн санал

4.4.3 Татвар болон Цагдаагийн хэлтсийн тодорхойлолт

4.4.4 Тухайн жилд онцгой амжилт гаргасан, амжилт бүтээлээ баталгаажуулах тайлан, түүнийг гэрчлэх баримт бичиг, зүйл

4.5. “Хүндэт иргэн” шагналд нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.
Үүнд:

4.5.1 Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг

4.5.2 Батлагдсан загварын дагуу анкет, 3х4 хэмжээтэй 1% гэрэл зурагтай

4.5.3 Ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт

4.5.4 Хамт олны хурлын тэмдэглэл

4.5.5 Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар

4.5.6 Бусад холбогдох бичиг баримт

4.6 Энэ журмын 3.2.1, 3.3.1-д заасан болзол хангасан хүний тодорхойлолт, шагнуулах тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг энэхүү журмын 4.4, 4.5-д заасны дагуу бүрдүүлж жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор дүүргийн Засаг даргын Тамгын газар ирүүлнэ.

4.7 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын хамтран баталсан ажлын хэсэг шалгаруулалтад ирүүлсэн материал болон нэр дэвшигч иргэд, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцаж дүгнэлт гаргах бөгөөд саналаа дүүргийн Засаг даргад танилцуулна.

4.8 Дүүргийн Засаг дарга уг саналыг дэмжсэн тухай тодорхойлолт, холбогдох материалыг Хурлын Тэргүүлэгчдэд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

Тав. Хамтарсан шагналын дагалдах мөнгөн шагнал, баталгаа

5.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын хамтарсан шагнал “Шилдэг аж ахуйн нэгж”-ийг төрөл тус бүрээр шалгаруулж, “Шилдэг аж ахуйн нэгж” цом өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

5.2 Дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөгдсөн иргэнд батламж, зүүсгэл, 500.000 /таван зуун/ мянган төгрөгөөр шагнаж урамшуулна.

5.3 Шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан байгууллага, “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөгдсөн иргэд байгууллагыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэг удаа үнэ төлбөргүй сурталчилах ажлыг дүүргийн Засаг даргын Тамгын газраас хариуцан гүйцэтгэнэ.

5.4 Дүүргийн “Шилдэг аж ахуйн нэгж”, “Хүндэт иргэн”-д олгох цом, батламж зүүсгэл хэвлүүлэх зардал, дагалдах мөнгөн шагналыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

5.5 “Шилдэг аж ахуйн нэгж”, “Хүндэт иргэн” шагналаар давхардуулан болон нэхэн шагнахгүй.

5.6 Хамтарсан шагналд Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар гарын үсэг зурна.

Зургаа. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналд нэр дэвшигчдэд тавигдах болзол, шаардлага

6.1 “Чандмань одон” нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал байна.

6.2 Улс эх орондоо олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, Төр захиргааны байгууллага, дүүрэг, орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан, иргэн, Төрийн албан хаагчийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор шагнана.

6.3 Чандмань одонд нэр дэвшигч нь дараах болзол, шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ Улсад 7 ба түүнээс дээш жил ажилласан. Үүнээс Чингэлтэй дүүргийн харьяа нутгийн захиргааны байгууллагад 4 ба түүнээс дээш жил ажилласан Төрийн албан хаагчийг

б/ Улсад 10 ба түүнээс дээш жил ажилласан. Үүнээс Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан ажилтан албан хаагчдыг

в/ Улсад 10 ба түүнээс дээш жил ажилласан, хороо, дүүрэг орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлагатай оролцдог, идэвхтэн гишүүд, иргэдийг

г/ Чандмань одонгоор шагнагдах иргэн нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал “Хүндэт-Өргөмжлөл”-өөр шагнагдсан байх.

6.4 “Чандмань одон”-оор шагнуулахаар дүүргийн болон хорооны Хурал тэдгээрийн Тэргүүлэгчид, Засаг дарга, Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс санал гаргаж болно.

6.5 “Чандмань одон” хүртсэн хүнд гэрчилгээ, мөнгөн шагнал олгоно.

6.6 Эрхэлсэн ажилдаа идэвх санаачлагатай өндөр амжилт гарган ажилласан, иргэн, Төрийн албан хаагчийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт Өргөмжлөл”-өөр шагнана.

6.7 “Хүндэт өргөмжлөл”-д нэр дэвшигч нь дараах болзол, шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ Улсад 5 ба түүнээс дээш жил ажилласан. Үүнээс Чингэлтэй дүүргийн харьяа нутгийн захиргааны байгууллагад 2 ба түүнээс дээш жил ажилласан Төрийн албан хаагчийг

б/ Улсад 5 ба түүнээс дээш жил ажилласан. Үүнээс Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан ажилтан албан хаагчдыг

в/ Улсад 5 ба түүнээс дээш жил ажилласан, хороо, дүүрэг орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвх санаачлагатай оролцдог, идэвхтэн гишүүд, иргэдийг

6.8 Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 5-аас доошгүй жил үйл ажиллагаа эрхэлж байгаа дүүргийн татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагыг Чингэлтэй дүүргийн ИТХ-ын шагнал “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнаж болно.

6.9 Чингэлтэй дүүргийн ИТХ-ын шагналыг Хүндэт өргөмжлөл, Чандмань одон гэсэн шат дарааллах зарчмаар, давхардуулахгүйгээр олгоно.

6.10 Урлаг спортын гарамгай амжилт гаргасан, эрхэлж буй ажил хөдөлмөрөөрөө онцгой гавьяа байгуулсан Төрийн албан хаагч, иргэдийг болзол шаардлага, хугацаа харгалзахгүйгээр “Чандмань одон”-оор шагнаж болно.

6.11 Ажлын амжилт гаргасан хүмүүсийг шагнахад дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал хоорондын зай 2-оос доошгүй жил байх бөгөөд урьд тогтоосон амжилтыг бататган ахиулсан байна.

Долоо. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналд нэр дэвшүүлэх

7.1 Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ.

7.1.1 Хурлын шагналд нэр дэвшигчийн анкет

7.1.2 Ажил байдлын тодорхойлолт

7.1.3 Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг

7.1.4 Иргэний үнэмлэхний хуулбар

7.1.5 Хамт олны хурлын тэмдэглэл

7.1.6 Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, лавлагаа

7.1.7 “Хүндэт Өргөмжлөл”-өөр шагнагдсан шагналын хуулбар

7.2 Дээрх баримт бичгийг бүрдүүлж тэмдэглэлт баяр ёслолын өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлнэ.

7.3 Шагналд нэр дэвшсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт, авьяас чадвар, оруулсан хувь нэмрийг товч, тодорхой бичсэн байх бөгөөд холбогдох судалгаа, үзүүлэлтийг хавсаргасан байна.

Найм. Шагналыг шийдвэрлэх

8.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулах тухай хүсэлтийг Ажлын албаны шагнал хариуцсан ажилтан холбогдох байгууллагаас хүлээн авч хянана.

8.2 Шагналын асуудал хариуцсан ажилтан шагнуулах тухай тодорхойлолт, холбогдох материалыг нарийвчлан судалж тогтоолын төсөл боловсруулан Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн даргаар хянуулан Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсний үндсэн дээр шийдвэрлүүлнэ.

8.3 Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцэн болзол хангаж, олонхын санал авсан хүмүүсийг нэр дэвшүүлж Тэргүүлэгчдийн тогтоол гарна.

Ес. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын дагалдах мөнгөн шагнал баталгаа

9.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал “Чандмань” одонг 50.000 /тавин мянган/ төгрөг дагалдана. Одонгийн үнэмлэх Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын үсэг, тамгатай, хувийн дугаартай байна.

9.2 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-ийг 30.000 /гучин мянган/ төгрөг дагалдана. “Хүндэт өргөмжлөл” нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын үсэг, тамгатай байна.

9.3 Одон, үнэмлэх, өргөмжлөлийн загварыг гаргах түүнд зарцуулагдах зардал болон дагалдах мөнгөн шагналыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

Арав. Шагналын мэдээллийн сан

10.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шагнагдсан хүмүүсийн цахим мэдээллийн сантай байна. Мэдээллийн санг шагналын төрөл, байгууллага ажилтны нэр огноогоор төрөлжүүлэн бүрдүүлнэ.

10.2 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын Тамгын газрын шагналын асуудал хариуцсан ажилтнууд хариуцна.